



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны *04* сарын *28* өдөр

Дугаар *135*

Улаанбаатар хот

Г Эрүүл мэндийн удирдлагын
мэдээллийн тогтолцооны үйл ажиллагааг
зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2012 оны 98 дугаар тогтоол, Эрүүл мэндийн яамны бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан эрүүл мэндийн салбарын хэмжээнд ажиллаж буй зохицуулах зөвлөл, комисс, хорооны удирдлага зохицуулалтыг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцооны үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 399 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 9 дэх заалтаар баталсан Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хүчингүйд тооцсугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А. Эрдэнэтуюя/-д даалгасугай.



Эрүүл мэндийн сайдын 2014 оны
04... сарын 28 өдрийн 135 дугаар
тушаалын хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН ТОГТОЛЦООНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- | | |
|-----------------------|--|
| Дарга: | Төрийн нарийн бичгийн дарга |
| Орлогч дарга | Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга |
| Нарийн бичгийн дарга: | Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцооны бодлого, хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн |
| Гишүүд: | Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга
Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга
Бодлого төлөвлөлтийн газрын Салбарын хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
Санхүү эдийн засгийн хэлтсийн Эмнэлгийн тусламж үйлчилгээний төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга
Улсын гуравдугаар төв эмнэлгийн дарга
Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга
Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын шинэчлэлийн бодлого төлөвлөлтийн дарга (зөвшилцсноөр)
Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн газрын дарга (зөвшилцсноөр)
Үндэсний статистикийн хорооны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны дарга (зөвшилцсноөр) |